

Улаанбаатар хотын усны нөөцийг нэмэгдүүлэх,
хүн амын ундны усны чанарыг сайжруулах
талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл “Улаанбаатар хотын хүн амын ундны усны нөөц”-ийн тухай Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Ц.Энхтүвшингийн илтгэлийг хэлэлцээд ЗӨВЛӨМЖ болгох нь:

Монгол Улсын Засгийн газарт:

Улаанбаатар хотын усны нөөцийг нэмэгдүүлэх, хүн амын ундны усны чанарыг сайжруулах ажлын хүрээнд дараах төслийн техник- эдийн засгийн үндэслэлийг боловсруулж Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд 2015 оны хоёрдугаар улиралд багтаан танилцуулах:

1. Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрт гадаргын ус ашиглах, Туул голын урсацыг тогтвортой байлгах, үерийн усыг хуримтлуулах, газрын доорх гүний усыг зохистой хэмжээнд барих зорилгоор “Туул усан цогцолбор барих” төсөл;

2. Улаанбаатар хотын бохир усны төв цэвэрлэх байгууламжийг өргөтгөж, технологийн иж бүрэн шинэчлэл хийх, гарсан цэвэршүүлсэн ус, лагийг эргүүлэн ашиглах төсөл;

3. Улаанбаатар хотын хүн амын ундны усны эрүүл ахуйн чанарыг сайруулах зорилгоор цэвэр ус түгээх болон ариутгах татуургын шугам хоолойг шинэчлэх, технологи нэвтрүүлэх төсөл.